



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/77/НА/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2022 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Оюунхэрлэн Утас: 70584207 Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит





2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,094,370.90	320,895,358.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,198,949.95	56,435,752.67
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.01	1.01
31110	Төгрөг	0.01	1.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,198,949.94	56,435,751.66
3121	Төгрөг	20,198,949.94	56,435,751.66
31213	Арилжааны банк дахь харилцах	20,198,949.94	56,435,751.66
33	АВЛАГА	8,570.95	163,615,552.43
33401	Дансны авлага /ТӨҮГ/	690.66	163,615,159.44
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	7,880.29	392.99
35	БАРАА МАТЕРИАЛ	50,886,850.00	100,844,053.67
351	Түүхий эд материал	15,616,598.00	51,497,208.01
35110	Тусгай зориулалттай материал	15,616,598.00	51,497,208.01
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,403,778.00	1,383,772.00
354	Хангамжийн материал	33,866,474.00	47,963,073.66
35410	Бичиг хэргийн материал	863,098.00	7,708,099.00
35420	Аж ахуйн материал	33,003,376.00	40,254,974.66
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	322,338,249.18	272,587,604.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	322,338,249.18	272,587,604.81
392	Биет хөрөнгө	322,004,643.73	272,270,679.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	236,571,479.71	236,571,479.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,828,573.98)	(17,742,860.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,500,000.00	29,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,500,000.00)	(29,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,704,549.00	130,640,707.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(61,541,396.50)	(82,445,268.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,187,540.00	18,150,640.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,088,954.50)	(12,904,018.50)
39301	Програм хангамж	645,866.00	645,866.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(645,866.00)	(645,866.00)
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	333,605.45	316,925.18
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	366,966.00	366,966.00
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	(33,360.55)	(50,040.82)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	393,432,620.08	593,482,963.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.01	0.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.01	0.01
413	Өглөг	0.01	0.01
4136	Бусад өглөг	0.01	0.01
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	(0.00)	0.01
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.02	-

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	393,432,620.32	593,482,963.57
51	Засгийн газрын хувь оролцоо	393,432,620.32	593,482,963.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	758,500,615.97	758,500,615.97
51101	Өмч: - төрийн	758,500,615.97	758,500,615.97
512	Хуримтлагдсан үр дүн	21,395,529.58	221,445,872.83
51210	Өмнөх үеийн үр дүн	21,395,529.58	21,395,529.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	200,050,343.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	(386,463,525.23)	(386,463,525.23)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	393,432,620.33	593,482,963.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	518,703,343.32	1,956,794,969.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	518,703,343.32	1,956,794,969.31
120	Нийтлэг татварын бус орлого	518,703,343.32	1,956,794,969.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	456,826,200.00	1,069,591,019.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	456,826,200.00	1,069,591,019.00
120009	Бусад орлого	61,877,143.32	887,203,950.31
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	453,548,854.74	1,756,744,626.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,548,854.74	1,720,854,577.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,548,854.74	1,720,854,577.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,983,642.00	442,845,217.00
210101	Үндсэн цалин	242,983,642.00	442,745,217.00
210104	Урамшуулал	-	100,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,308,306.57	52,560,757.88
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	52,560,757.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,358,657.01	10,843,439.74
210301	Гэрэл, цахилгаан	6,434,653.01	7,919,438.74
210304	Байрны түрээс	2,924,004.00	2,924,001.00
2104	Хангамж, бараа материалын зардал	159,603,995.00	1,141,666,209.50
210401	Бичиг хэрэг	24,162,539.00	23,940,381.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,172.76	1,343,571.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	24,532,894.22	18,819,068.16
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	2,596,705.85	2,560,053.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	107,111,683.17	1,095,003,136.34
2107	Томилолт, зочны зардал	564,000.00	812,000.00
210702	Дотоод албан томилолт	564,000.00	812,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	548,622.89	529,180.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,400.00	359,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,440.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	110,022.89	90,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,181,631.27	21,597,772.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,393,720.00	42,487,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	510,000.00	460,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,277,911.27	28,649,902.93
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	35,890,049.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	35,890,049.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/		35,890,049.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>65,154,488.58</u>	<u>200,050,343.26</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>65,154,488.58</u>	<u>200,050,343.26</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,500,615.97	-386,463,525.23	21,395,529.57	393,432,620.31
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	758,500,615.97	-386,463,525.23	21,395,529.57	393,432,620.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,500,615.97	-386,463,525.23	21,395,529.57	393,432,620.31
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,500,615.97	-386,463,525.23	21,395,529.57	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	758,500,615.97	-386,463,525.23	21,395,529.57	393,432,620.31
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	200,050,343.26	200,050,343.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,500,615.97	-386,463,525.23	221,445,872.83	593,482,963.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	457,548,922.10	938,306,715.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	722,722.10	32,330,796.00
120	Нийтлэг татварын бус орлого	722,722.10	32,330,796.00
120009	Бусад орлого	722,722.10	32,330,796.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	456,826,200.00	905,975,919.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	456,826,200.00	905,975,919.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	456,826,200.00	905,975,919.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	440,894,118.51	894,069,203.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,894,118.51	894,069,203.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,894,118.51	894,069,203.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,069,780.70	373,640,974.18
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	373,640,974.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,529,267.30	97,225,293.89
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	26,529,267.30	97,225,293.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,712,520.66	35,701,978.74
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	17,712,520.66	35,701,978.74
2104	Хангамж, бараа материалын зардал	163,821,264.85	350,234,888.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	2,926,705.85	2,560,053.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	160,894,559.00	347,674,835.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,761,285.00	37,266,068.47
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	19,481,105.00	36,831,008.47
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,274,780.00	359,400.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	5,400.00	75,660.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,654,803.59	44,237,511.72
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	12,170,469.00	3,325,511.00

140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	12,170,469.00	3,325,511.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,729,831.00	11,326,220.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,729,831.00	11,326,220.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,729,831.00	11,326,220.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	10,729,831.00	11,326,220.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	1,440,638.00	(8,000,709.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,095,441.59	36,236,802.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,103,508.36	20,198,949.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,198,949.95	56,435,752.67

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэрлэн сумын Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Оюунхэрлэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэрлэн сумын Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь: Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил



гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжтэй бөгөөд хяналтын байгууллагын дотоод аудитын нэгж хэрэгжүүлдэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга


Бараа материалын дансны үлдэгдэл 100.8 сая төгрөг болж өмнөх оноос 49.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 415.8 сая төгрөг болж өмнөх оноос 21.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь 14.7 сая төгрөгийн худалдан авалт хийж, 35.8 сая төгрөгийн хөрөнгө актaлсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт



Тус байгууллага нь 2021 оны төсвийн төслийг төвөөр үйлчлүүлсэн хөдөлгөөнт хүн ам, бүртгэлгүй иргэн, түр оршин суугаа иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас нийт 938.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 894.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд 163.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь тухайн оны ковидоор өвчилсөн иргэдийн гэрийн хяналтын зардлын санхүүжилт ороогүйтэй холбоотой байна. Үүнтэй холбоотой өглөг үүсээгүй, бараа материал болон харилцах дансны үлдэгдэл хангалттай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн дагуу мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн дагуу бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал



Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 9.1 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Албан шаардлага

Бараа материалын тооллого хангалтгүй, нэр төрлөөр нь тоолоогүй бөгөөд тооллогын илтгэх хуудасны дүн санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хэрлэн сумын Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төв	1		-	-	-	-	1	9.1		